

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙ								
Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (прораммын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл	СӨҮТ-ийн санал
1	Нумын наалт /гичир/– Хүннү гүрний үе	Y-96-2-21 I Y-96-2-21 II Y-96-2-21 III Y-96-2-21 IV Y-96-2-21 V	5	32.8x3.9 см Жин-0,25 гр 28x1.1 см 26.7x1.8 см 22x1.3 см 33x3.7 см	1110МЦМ0046 3 1110МЦМ0046 4 1110МЦМ0465 1110МЦМ0046 6 1110МЦМ0046 7	1986 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн археологийн хээрийн шинжилгээний ангийн судлаачид Говь-Алтай аймгийн Цогт сумын Хиргист хоолой Хүннүгийн үед холбогдох булшнаас олж илрүүлсэн. “Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” I боть, 2014 он “Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.	Монгол цэргийн түүхэнд холбогдох ховор, биет түүх соёлын дурсгалт өв	Дэмжсэн
2	Дуулга - хүрэл	Y-04-2-1	1	Өндөр 24,5 см Өргөн 18,5 см Жин 1,73 кг	1110МЦМ0079 7	Хүрлээр хэвэнд цутгаж хүрэл хайлуулдаг технологээр хийгдсэн. Дуулганы ар тал нь хүзүү хамгаалсан ирмэгтэй. Дуулга нь дээд талаараа дугуй хэлбэртэй уртаашаа зуйван, нүүрэн талаасаа ар луугаа сунасан хэлбэртэй, орой дээрээ гогцоотой /гогцоотойгоо/ 14 см, урт нь 24,5 см, өргөн нь 14 см, гогцоо нь дугуй хэлбэртэй, өргөн нь 4,4 см, өндөр нь 1,1 см, зузаан нь 0,5 см, урд	Эртний нүүдэлчдийн цэргийн урлагийг судлахад маш их сонирхол татаж байгаа нэгэн дуулга нь манай музейн үзмэрт буй хүрэл дуулга юм. Хүрлийн үед холбогдох дуулга Монгол нутгаас өнөөгийн байдлаар 4 ширхэг олдсоны хамгийн сүүлд олдсон, бүртгэгдсэн нь энэхүү хүрэл дуулга юм. Энэ дуулгыг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутагт орших Хятрууны нуруу хэмээх газрын орчмоос нутгийн иргэн олж, 2003 онд тус музейд худалдсан. Энэ дуулга нь хүрэл зэвсгийн үеийн нүүдэлчдийн	Дэмжсэн

						<p>талаараа босоо хагас дугуй хэлбэртэй энэ нь цохны хамгаалалт болж байна.</p> <p>Энэ 2 нүдний зориулалтын дугуй хэсэг нь зузаан ирмэгтэй. Цохны хамгаалалтын үзүүрээс дээд гогцоо хүртэл босоо гурвалжин хурц ирмэгтэй. Дуулганы доод хэсэг нь шулуун хэлбэртэй. Хүзүүний хамгаалалтыг бэхлэх зориулалттай хоорондоо 1 см зайтай нүхнүүдтэй, нүхний диаметр 0,5-0,6 мм хэмжээтэй.</p> <p>Археологи судлал -2005 он Н.Эрдэнэ-Очир Археология, этнография и антропология Евразии. 2010 1 (41) 2010 “Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.</p>	цэргийн зэвсэг хэрэглэлийн үйлдвэрлэл өндөр хөгжсөн байсныг гэрчлэн нотлох дурсгал юм.	
3	Дээл-харуулын цэргийн	Ү-96-7-1	1	Урт-158 см Өргөн-83,7 см Жин-8,35 кг	1110МЦМ0065 0	<p>Энэхүү дээлийг XVI-XVII зууны үед харуулын цэргүүдэд зориулж, гар аргаар хийсэн.</p> <p>Хүр хорхойн шүлснээс гаргаж авсан хөвөн дотортой. Энэхүү дээлийн дотор нь сумны зэвэнд шингээсэн хорыг хүний биед нэвтрэхээс хамгаалдаг учраас эртний Монголчууд хүр</p>	Цор ганц түүх соёлын өв	Дэмжсэн

						<p>хорхойн шүлснээс гарган авсан хөвөнг ашигладаг байжээ. Дээлийн баруун урд, хойд хормой оноотой хийсэн комбинзон байдалд оруулж товчлон моринд мордож буухад хялбар болгож.</p> <p>“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” I боть, 2014 он</p> <p>“Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.</p> <p>“Монгол цэргийн дүрэмт хувцас” 2022 он</p>		
4	Сэлэм-маршал /хуйтай/	Ү-99-1-637	1	<p>Урт-96 см Хуйны урт-90 см Өргөн-4 см Жин-1,7 см</p>	1110МЦМ0002 8	<p>XX зууны Монгол улсын түүхэнд цэргийн дээд алдар цол болох маршал цолыг хүртсэн 3 хүн байдаг. БНМАУ-ын маршалын ёслолын сэлэмний эх зургийг төрийн шагналт зураач Д.Чойдог агсан зохиож,ЗХУ-д 1944 онд захиалгаар хийлгэсэн. Монгол Улсын эрдэнэсийн санд хадгалагдаж байгаад тус музейн сан хөмрөгт 1990 онд шилжүүлгээр иржээ. 583 сорьцтой, 11 газар хэсэгчлэн алтаар бүрсэн, үүнд алхан хээ 3 ширхэг, угалзарсан хээ 7 ширхэг, 2 талд нь 2 ширхэг өлзий хээг алтаар хийсэн. Энэхүү</p>	<p>Монгол улсын түүхэнд мөнхөрсөн 3 маршалын түүхэнд холбогдох дахин давтагдашгүй түүх, соёлын дурсгал</p>	Дэмжсэн

						<p>сэлэм нь нийт 137 ширхэг үнэт эрдэнийн чулуун шигтгээтэй. Үүнд рубин 46 ширхэг, маргад 81 ширхэг, доржпалам 4 ширхэг, цагаан шигтгээ 8 ширхэг, сэлэмний бариул дээр 47 ширхэг оюу, маргад шигтгэжээ. Мөн сэлэмний хуй нь 2 ширхэг алтан гархитай.</p> <p>“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” I боть, 2014 он “Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.</p>		
5	Дүрэмт хувцас-маршалын ёслолын Мундер Өмд Бүс Малгай	Y-00-3-3 I-III Y-97-1-31	1 иж	Урт-71,4 см Өргөн-54,5 см Размер-52 Размер-52	1110МЦМ0065 5 1110МЦМ0065 6 1110МЦМ0065 7 1110МЦМ0065 2	<p>БНМАУ-ын маршал Х.Чойбалсангийн ёслолын мундер. Энэхүү мундерийн загварыг 1944 оны 4 дүгээр сарын 18-ны Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 22 дугаар тогтоолоор баталсан. Маршал Х.Чойбалсан 1944-1952 оны хооронд баяр ёслолын үед өмсдөг байжээ. Саарал диагнал даавуун гадар, бор саарал атласан дотортой. Алтан шар саан утсаар мөрдөсийг нь урласан. Дугуй цацагтай эполетний /мөрдөс/</p>	Энэхүү дүрэмт хувцас нь ганцхан маршал Х.Чойбалсанд зориулан хийснээрээ онцлог бөгөөд дахин давтагдашгүй ховор үзмэр юм.	Дэмжсэн

						алтадсан утасны алтны орц 60 гаруй хувьтай. “Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” I боть, 2014 он “Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он. “Монгол цэргийн дүрэмт хувцас” 2022 он		
6	Пикеж-маршалын	Ү-97-1-26	1	Размер-56 Урт-122 см Өргөн-57,5 см	1110МЦМ0065 1	БНМАУ-ын маршал Х.Чойбалсангийн пикеж нь 1944 оны 4 дүгээр сарын 18-ны Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн 22 дугаар тогтоолоор батлагдсан загвараар хийгдсэн. Өдөр тутам өвлийн улиралд өмсөх зориулалттай, каракул захтай. 127 ширхэг өмхий хүрэнгийн арьсыг зоолж, сүүлтэй арьсыг эгнүүлэн доторлосон, ногоон диагональ даавуун гадартай. Маршал Х.Чойбалсан 1944-1952 оны үед өмсөж байсан.	Тус пикеж нь зөвхөн маршал Х.Чойбалсанд зориулан хийгдсэн цорын ганц эх хувь үзмэр юм.	Дэмжсэн
7	Тэмдэг - БНМАУ-ын баатрын анхны загвар	Ү-90-4-29	1	Диа -3,2 см Жин-43.9 гр	1110МЦМ0000 1	Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн өдрийн 43 дугаар тогтоолоор баталжээ. “Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” I боть, 2014 он	БНМАУ-ын “Улсын баатар” цолтны тэмдгийн анхны загвар	Дэмжсэн

						“Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.		
8	Одон-Алтан гадас	Ү-90-4-32	1	5,4x4,8 см Жин-58.5 гр	1110МЦМ0036 3	Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1936 оны 6 дугаар сарын 87 дугаар тогтоолоор баталжээ. “Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” I боть, 2014 он “Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.	Улс орныг батлан хамгаалах ажилд онцоор зүтгэгчдийг шагнах зорилгоор анх гаргасан “Алтан гадас” одонгийн анхны загвар	Дэмжсэн
9	Туурган зураг-Халхын голын тулалдаан	Ү-97-1-39	1	1800см x420 см	1110МЦМ0079 8	Халхын голын байлдааны 1939 оны 8 дугаар сарын 20-ны шийдвэрлэх давшилтыг бүхэлд нь харуулсан. Монгол Зөвлөлтийн армийн нэгдүгээр бүлгийн давшилтын зүүн жигүүрт үүрэг гүйцэтгэж байгаа МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн атакиг үзүүлэхдээ алаг морьт Л.Дандар баатрыг, баруун гарт үүрэг гүйцэтгэсэн МАХЦ-ийн 8 дугаар морьт дивизийн давшилтын эхэнд хүрэн халзан морьтой дивизийн дарга хурандаа Д.Нянтайсүрэнг тус тус дүрсэлсэн зэрэг бодитой үйл явдлуудыг маш тодорхой судалгааны үндсэн дээр зурснаараа онцлогтой. Ардын хувьсгалын 50 жилийн	Уг бүтээлийг Халхын голын дайнд биечлэн удирдаж оролцсон БНМАУ-ын баатар Ж.Лхагвасүрэн, Л.Дандар, Д.Нянтайсүрэн нар газар орон дээр нь зөвлөж, зуруулсан түүхтэй, том хэмжээний бүтээл юм.	Дэмжсэн

						<p>ойн босгон дээр дайнд оролцсон залуу жанжин Ж.Лхагвасүрэн, гарамгай баатар Л.Дандар, хурандаа Д.Нянтайсүрэн нар газар орон дээр нь зураачдын хамт очиж өөрсдийн биеэр зөвлөхөөр ажиллажээ. “Б.Дашням” УГЗ-тэн Б.Дашнямын уран бүтээлийн катологи. 2010 он “Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.</p>		
10	Уран зураг-Тулалдааны дараахи амсхийлт	Ү-90-4-78	1	146x226 см	1110МЦМ0034 7	<p>Зөвлөлтийн зохиолч Твардовскийн “Василий Тёркин” хэмээх шүлэглэсэн зохиолыг сэдэвлэж зураач Ю.Н.Непринцев “Тулалдааны дараахи амсхийлт” бүтээлээ зуржээ. Энэхүү бүтээлээрээ зураач Ю.Н.Непринцев ихэд алдаршиж Сталины нэрэмжит төрийн шагнал хүртжээ. Зураач Ю.Н.Непринцев “Ялалтын маршал” /Г.К.Жуковт/-д энэхүү зураг зайлшгүй байх ёстой гэж үзэн анхны эх зурагнаасаа арай бага хэмжээгээр зурж түүнд бэлэглэсэн. 1969 онд Халхын голын ялалтын 30 жилийн ойгоор</p>	<p>Бүтээлийн анхны эх нь дэлхийн уран зургийн санд бүртгэлтэй байдаг ба хэмжээг багасган дахин зурсан эх бүтээл гэдгээрээ үнэ цэнэтэй.</p>	Дэмжсэн

					<p>маршал Ю.Цэдэнбал Москвад очиж маршал Г.К.Жуковыг БНМАУ-ын “Баатар цол”-оор шагнасныг гардуулахад маршал Г.К.Жуков талархан түүнд “Тулалдааны дараахи амсхийлт” хэмээх эх бүтээлээ дурсгасан түүхтэй. Уг зурагт Ю.Н.Непринцев өөрийгөө дайчдын дунд маш баясгалантайгаар инээн зогсож буйгаар дүрслэн бусад 20 гаруй нөхдийг хүн бүрийн зан чанар төрхийг маш бодитойгоор дүрслэн зурснаараа онцлог юм.</p> <p>“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” I боть, 2014 он “Монгол цэргийн музейн үзмэрийн дээжис” 2016, 2021 он.</p>	
--	--	--	--	--	---	--